

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Төрийн албаны зөвлөлийн тогтоол

Дагаж мөрдөх огноо: 2022.01.03

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2022.1.03

Байгууллагын нэр:

ХӨСҮТ

Албан тушаалын нэр:

Албаны дарга

Ажлын цаг:

8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн бүс

Нэгжийн нэр:

Чанар аюулгүй байдлын алба

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮЭМ-6

Ажлын байрны албан ёсны байршил:

БЗД, 14-р хороо, Намъянжүгийн гудамж

Онцгой нөхцөл:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго: Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах, чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, тогтвортой байдлыг хангах, тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, эрсдэлтэй холбоотой хууль, тогтоомж бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлийн тайлан үнэлгээ хийх, тайлагнах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг батлагдсан стандарт, удирдамжийн дагуу мэргэжлийн түвшинд үзүүлэх

Албан тушаалын зорилт:

1. Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах
2. Чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх
3. Албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, тогтвортой байдлыг хангах
4. Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлтэй холбоотой хууль тогтоомж бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлийн үнэлгээ хийх тайлагнах
5. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх
6. Сургалтанд хамрагдах, эрдэм шинжилгээ судалгааны ажил эрхлэх

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэ-лийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах зорилтын хүрээнд	1. Байгууллагын зорилго, үйл ажиллааны төлөвлөгөөтэй уялдуулан тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах 2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж зааврын мөрдөлтийг хэрэгжилтийг хангуулах удирдан зохион байгуулах арга хэмжээг зохион байгуулах 3. Хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ, магадлан итгэмжлэл, мэргэжлийн шалгалтын дүн, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах 4. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлүүлэх, эргэн мэдээлэх 5. Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр санал боловсруулан удирдах зөвлөл, удирдлагад танилцуулах	1.Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах батлуулсан төлөвлөгөө 2.Зохион байгуулсан сургалт, шалгалт, өгсөн зөвлөгөөний тоо 3.Хяналт үнэлгээ, шалгалтын дүгнэлт, өгсөн зөвлөмж, авсан арга хэмжээний тайлан 4. Санал гомдлын тоо, авсан арга хэмжээ 5. Боловсруулсан саналын тоо, хурлын протокол	Шийдвэрлэх Хянах
Чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд	1. Байгууллагын алба, тасгуудын чанар аюулгүй байдлын багийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ өгөх, үйл ажиллагааны хэвийн байдлыг хангахад дэмжлэг туслалцаа үзүүлэх 2. Гүйцэтгэлийн үнэлгээнд чанар, аюулгүй байдлын чиглэлээр хийсэн ажлыг үнэлэх шалгуурыг хянах батлуулах	1.Үнэлгээний дүн 2.Гүйцэтгэлийн үнэлгээнд чанар аюулгүй байдлын чиглэлээр шалгуур үзүүлэлт орсон байдал	Шийдвэрлэх
Албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд	1. Чанарын алба, багийг чанарын удирдлагаар хангаж, чанарын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах 2. Хүний нөөц, лаборатори, сувилахуй, эм зүй, нян судлал, санхүү аж ахуй болон тасаг нэгжүүдийн уялдаа холбоог хангаж, чанар сайжруулах үйл ажиллагаанд хамт олны оролцоог нэмэгдүүлэх 3. Шинээр ажилд орсон эмч, мэргэжилтэнүүдэд чанар, аюулгүй байдал, эрсдэлийн чиглэлээр сургаж чадавхижуулах ажлыг зохион байгуулах 4. Байгууллагын удирдлага, эмч, ажилтны ажлын байрны тодорхойлолтонд тусламж	1.Тасаг нэгжүүдийн чанарын багийн төлөвлөгөө, биелэлт 2. Чанар сайжруулах ажлын хамтарсан хурлын шийдвэр 3.Хийсэн сургалтын тоо, хамрагдсан ажилчидын бүртгэл 4.Ажлын байрны тодорхойлолтод тусгасан зорилго	Шийдвэрлэх

	үйлчилгээний чанар, аюулгүй байдлын талаар тусгах		
Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлтэй холбоотой хууль тогтоомж бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлийн үнэлгээ хийх тайлагнах зорилтын хүрээнд	- Халдварын хяналт ,сэргийлэлтийн мөрдөлтөнд хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах - Үйлчүүлэгч, эмнэлгийн ажилтны аюулгүй байдал, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн тогтолцоо, зохион байгуулалтын талаар санал гаргах, шийдвэрлүүлэх, үр дүнг тооцох - Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдолыг бүртгэх мэдээлэх, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах, эргэн мэдээлэх тогтолцоог бий болгон удирдан зохион байгуулах - Үйлчлүүлэгчийн санал гомдол, сэтгэл ханамжийн судалгааг зохих журмын дагуу авах, судалгааны үр дүнг шийдвэр гаргалт, төлөвлөлтөнд ашиглах, арга хэмжээ авах	- Өгсөн зөвлөгөө, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ - Эрсдэл аюулгүй байдлын төлөвлөгөө, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн - Бүртгэгдсэн тохиолдолын тоо - Сэтгэл ханамжийн судалгааны дүн	Шийдвэрлэх Хяналт
Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд	- Эмнэлгийн тусламж үйлчилгээг стандарт, удирдамжын дагуу цаг алдалгүй үзүүлэх - Эмнэлгийн тусламж үйлчилгээг стандарт, удирдамжын дагуу цаг алдалгүй , зөв зохистой явуулж байгаад хяналт хийх - Жижүүр эмчийн үүргийг хуваарийн дагуу гүйцэтгэх	- Өвчний түүхийн бичилт, эмчилгээ, үйлчилгээний гомдол - Өвчний түүхийн хяналт хийсэн баримт - Жижүүрийн хуваарь, үйлчилсэн өвчтөний тоо	Хяналт Хариуцан гүйцэтгэх
Сургалтанд хамрагдах, эрдэм шинжилгээ судалгааны ажил эрхлэх зорилтын хүрээнд	- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, судалгааны илтгэл, өгүүлэл бичих - Төгсөлтийн дараах сургалтын багц цагийн хөтөлбөрт багтах - Эмчилгээний стандарт, удирдамж, гарын авлага, мэргэжлийн ном туурвихад оролцох	- Судалгааны өгүүлэл, илтгэлийн тоо - Багц цагийн биелэлт - Оролцсон удирдамж, стандарт, номны тоо, материал	Хариуцан гүйцэтгэх

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд
Мэргэжил	Хүний их эмч
Мэргэшил	Халдвартын эмч
Туршлага	Эрүүл мэндийн байгууллагад 8-аас доошгүй жил ажилласан
Ур чадвар	Эрдмийн болон мэргэжлийн зэрэг цолтой
	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай
	Багаар ажиллах чадвартай
	Ёс зүйн тохиолдол зөрчил гаргаж байгаагүй

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: ХӨСҮТ-ийн Ерөнхий захирал

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

1. Чанарын менежер, халдвар судлаач эмч
2. Клиникийн тасгуудын эмч, ажилчид
3. Ариутгал, гал тогооны тасгийн эмч, ажилчид
- 4.

Нийт:4

Бусад харилцах субъект

Нийт

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал: Хүний нөөцийн менежер
..... /А.Жавзандулам/

Байгууллагын нэр: ХӨСҮТ

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

Шийдвэрийн огноо: 2022.01.03

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

Дугаар:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ХӨСҮТ

Шийдвэрийн огноо: 2022.01.03

Дугаар: 01.....

(тамга/тэмдэг)

..... /Ц.Билэгтсайхан/ Ерөнхий захирал
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20~~22~~ оны 1. дугаар сарын 18-ны өдөр